

ОЮУТНЫ ЭРДМИЙН БАГА ЧУУЛГАН-2018 ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн “Оюутны эрдмийн бага чуулган 2018” 4-р сарын 30-ны өдөр зохион байгуулагдаж нийт 35 багш, 76 оюутан оролцлоо. Энэ удаагийн эрдмийн хурал 2 шаттай явагдсан ба 1-р шатанд 36 илтгэл ирснээс 16 илтгэл шалгарч ЭШ-ний хуралд аман хэлбэрээр хэлцэгдсэн байна.

Хуралд БУ-ы магистр Ц.Ундрах багш урилгаар оролцож “Эерэг хандлага” сэдвээр оюутан суралцагчдад лекц уншлаа.

Шүүгчдийн зүгээс хурлын үйл ажиллагааг дүгнэж хэлэхдээ: оюутнуудын судалгааны ажлын чанар өмнөх жилээс ахисан, асуудал дэвшүүлсэн судалгаануудыг хийсэн байна. Мөн асуумж судалгаанаас гадна судалгаанд оролцогчид холбогдох шинжилгээнүүдийг оюутан түшиц эмнэлгийн лабораторийг түшиглэн хийсэн нь сайшаалтай байна гэж онцлон хэллээ.